3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	13,529,139.3	30,110,432.2
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,410.0	
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	13,527,729.3	30,110,432.3
5	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	13,529,139.3	30,110,432.3

Авлага дансны үлдэгдэл дэх 7210.6 мянган төгрөг нь 2010 оноос хойш он дамжин бүртгэгдсээр байгаа ба авлага барагдуулах хуулийн этгээдийн үйл ажиллагаа зогсож, улсын бүртгэлээс хасагдсанаар хариуцах эзэн холбогдогч нь тодорхойгүй болж, улмаар тус авлагыг барагдуулах нэхэмжлэлийг шүүхийн байгууллага хүлээж авахгүй байгаагаас шалтгаалж насжилт өндөртэй, найдваргүй авлагын ангилалд шилжсэн байна.

Бараа материалын дансны 399121.0 мянган төгрөгийн үлдэгдэлд үндсэн хөрөнгийн шинж чанар бүхий нийт 41 нэр төрлийн 52 ширхэг 55264.1 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэгдсэнээс гадна өмнөх онуудад хийгдсэн вакуум цонх, хаалга, зэрэг зардлын шинж чанартай 22310.7 мянган төгрөгийн хөрөнгийг зарлагадаагүй байгаа нь нөлөөлжээ.

Энэ нь санхүүгийн байдал болон үр дүнгийн тайланг үнэн зөв илэрхийлээгүй, бүртгэл тооцооллын холбогдох журам, стандартад нийцээгүй байна.

Үндсэн хөрөнгө данс 16605578.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд хөрөнгө оруулалт, хандив болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 18372504.0 мянга, урсгал төсвийн худалдан авалтаар 466255.2 мянга, нийт 18838759.3 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж,

16236.0 мянган төгрөгийн хөрөнгө акталж, түүнчлэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийн нөлөөллөөс цэвэр хөрөнгийн үлдэгдэл дүн 29704100.6 мянган төгрөг болжээ. Хүснэгтээр харуулбал:

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
Үндсэн хөрөнгө	17,775,280.8	18,838,759.3	16,236.0	36,597,804.0
Хуримтлагдсан элэгдэл	(4,676,758.4)	(2,233,181.0)	(16,236.0)	(6,893,703.4)
Цэвэр дүн	13,098,522.4	16,605,578.2	-	29,704,100.6

Тайланд онд нийт 18372504.0 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авснаар бүртгэснийг дэлгэрэнгүй харуулбал:

- Барилга байгууламж дансанд Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар 50 ортой хүүхдийн эмнэлэг 4907744.3 мянга, Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалт, Хөшөөт хөгжил сангийн хөрөнгө оруулалтаар нэгдсэн эмнэлгийн дээвэр, сантехникийн засвар, манаачийн байрыг нийт 305838.4 мянган төгрөгөөр,
- Бельги улсын Засгийн газраас Toyota Landcruiser, Toyota Hiace маркийн 2 автомашиныг 596883.7 мянган төгрөгөөр,
- Бельги улсын Засгийн газраас 12447924.8 мянга, Глобал сангаас 10000.0 мянга, Люксембургийн Засгийн газраас 15115.3 мянга, орон нутгийн хөгжлийн сангаас 8250.0 мянга, Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар 36370.0 мянга, ХӨСҮТ-өөс 1333.3 мянга, Мобиком корпорацаас 9000.0 мянга, 2000 оны төгсөгчдийн хандив 25935.0 мянга, нийт 12553928.4 мянган төгрөгийн эмнэлгийн зориулалтын тоног төхөөрөмж,
- 3 хувийн эмнэлэг, 1 төрийн бус байгууллагаас нийт 2109.2 мянган төгрөгийн тавилга эд хогшил
- 2000 оны төгсөгчдөөс 4500.0 мянга, Хаан банкнаас 1500.0 мянган төгрөгийн бусад хөрөнгийг хандиваар хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна.

Биет бус хөрөнгөд 30015.0 мянган төгрөгийн өртөгтэй, 28887.5 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй программ хангамж, 816228.0 мянган төгрөгийн үнэлгээтэй газар бүртгэлтэй байна.

Өр төлбөр дансны оны эхэн дэх үлдэгдэл нь Цус сэлбэлт үндэсний төвд 1410.0 мянган төгрөгийн материалын тооцоо байсан ба тайлант онд бүрэн барагдуулсан байна.

Засгийн газрын оруулсан капитал дансны үлдэгдэл оны эхэнд 6876720.5 мянган төгрөг байсан ба тайлант онд өөрчлөлт ороогүй байна.

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	Зөрүү
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	9,337,241.9	29,756,674.6	20,419,432.7
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	9,655,551.1	13,173,971.6	3,518,420.5

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 20,419,432.7 мянган төгрөгөөр буюу 3.2 дахин өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс орлого материаллаг хэмжээгээр нэмэгдсэн шалтгаан нь тайлант онд үнэ төлбөргүй 18046850.1 мянган төгрөгийн хөрөнгө хүлээн авсан, түүнчлэн эрүүл мэндийн даатгалын сан болон улсын төсвийн санхүүжилт өмнөх оноос 2277876.7 мянган төгрөгөөр өссөн нь гол нөлөө үзүүлжээ.

Нийт зардал өмнөх оноос 3518420.5 мянган төгрөгөөр буюу 1.4 дахин өссөн байна. Өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад материаллаг өөрчлөлтөд цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл 1447809.0 мянга, эмийн зардал 632246.9 мянга, үндсэн хөрөнгийн

элэгдэл, хорогдол 1329464.7 мянган төгрөгөөр тус тус өссөн нь ихээхэн нөлөө үзүүлсэн байна.

Дээрх зардлууд өссөн шалтгаан нь Засгийн газрын тогтоол, шийдвэрийн дагуу цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал нэмэгдсэн, мөн үндсэн хөрөнгө материаллаг хэмжээгээр нэмэгдсэнээс шалтгаалж элэгдлийн зардал нь өмнөх оны үзүүлэлтээс тус тус өссөн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүнд нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 13785750.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 13785750.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 2763195.0 мянган төгрөгөөр бууруулж 11022555.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд батлагдсан төсөв өмнөх оныхоос 2477983.7 мянган төгрөгөөр өссөний дийлэнхид дараах зардлууд материаллаг буюу гол нөлөө үзүүлжээ. Үүнд: Цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл 1482040.7 мянга, эмийн зардал 480017.8 мянга, урсгал засварын зардал 373750.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал өмнөх оноос материаллаг хэмжээгээр өссөн нь Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоож нэмэгдүүлснээс шалтгаалсан байна.

Эм, урсгал засварын зардлыг ковид-19 вирусын өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлын нөхцөл шаардлагын улмаас нэмэгдүүлэн баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 11022555.4 мянган төгрөгийн төсөв баталснаас 5283833.6 мянган төгрөгийг улсын төсвөөс, 5450702.9 мянган төгрөгийн эрүүл мэндийн даатгалын сангаас, 288018.9 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс санхүүжилт бүрэн авч, эрүүл мэндийн даатгалын сангаас 5382487.1 мянган төгрөгийн санхүүжилт авч 68215.8 мянган төгрөг дутуу, үндсэн болон туслах үйл ажиллагаанаас 304384.5 мянган төгрөгийн орлого, нийт 10970705.2 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 10948397.8 мянган төгрөгийг зарцуулж 22307.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 10948397.8 мянган төгрөг буюу 99.3 хувьтай байгаа нь эмнэлгийн тусламж үйлчилгээ хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагааны буюу эмийн зардлыг 71246.3 мянга, урсгал засварын зардлыг 2911.3 мянга, нийт 74157.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

Хөтөлбөр	Зориулалт	Арга хэмжээ	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт
71602	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	10,683,485.3	10,609,327.7	74,157.6
71602	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	7,100.0	7,100.0	-

71602	81611	Төр хариуцах эмнэлгийн тусламж	331,970.1	331,970.1	-
ДҮН			11,022,555.4	10,948,397.8	74,157.6

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Эмийн худалдан авах ажиллагааг анх нийт батлагдсан төсвийн 85 хувийг тендер шалгаруулалтаар гэрээ байгуулж авахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 70 хувьд нь тендер шалгаруулалтаар зохион байгуулжээ.

2020 оны эм эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуурын тендерийн захиалгыг 35 багцаар 332 нэр төрлийн эм тариа, 33 нэр төрлийн ариутгал халдваргүйжүүлэх уусмал, 198 нэр төрлийн нэг удаагийн болон бусад эмнэлгийн хэрэгсэл, 24 нэр төрлийн гемодиализ болон хэвлийн диализын хэрэгсэл, 84 нэр төрлийн шүдний эмчилгээний материал, 350 нэр төрлийн лабораторийн урвалж оношлуур хэрэгсэл, нийт 1021 нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгслийн тендер зарласан байна.

Нээлттэй тендер болон Эрүүл мэндийн яаманд зарласан ерөнхий тендерт шалгарсан 36 эмийн компанитай нийт 1,434,932.0 мянган төгрөгийн эм тариа худалдан авах гэрээ байгуулсан ч гүйцэтгэлээр 1,852,974.0 мянган төгрөгийн эм тариа авч, 418,042.0 мянган төгрөгийн эмийг тендер, гэрээгүй шууд захиалгаар, мөн эмийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий 27 аж ахуйн нэгжээс 104,049.6 мянган төгрөгийн шууд худалдан авалт хийхэд дараах хүчин зүйлүүд нөлөөлжээ.

- Шуурхай штабын багаар шийдвэрлэж Ковид-19 цар тахлын хүрээнд бэлэн байдал хангах, тусламж үйлчилгээнд хэрэглэх зорилгоор эм тариа яаралтай бэлтгэх,
- Зарим онцлог эм, эмийн эмнэлгийн хэрэгслүүдийг тусгайлан захиалга өгч яаралтай бэлтгэх.

Тайлант хугацаанд 504242.5 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг гэрээ, шийдвэргүйгээр худалдан авсан байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас сар бүр санхүүжилтэд нийт 130016.0 мянга, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 63599.4 мянга, орон нутгийн төсвөөс 30370.0 мянга, Эрүүл мэндийн газраас шүүхийн шийдвэр барагдуулах 19000.0 мянга, нийт 242985.4 мянган төгрөгийн орлогыг хууль, журамд нийцүүлэн бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс, нэмэгдэл урамшуулалд 36080.8 мянга, бичиг хэргийн зардалд 10581.0 мянга, эмийн зардалд 52646.2 мянга, багаж техник хэрэгсэлд 31217.0 мянга, урсгал засварын зардалд 93460.4 мянга, шүүхийн шийдвэрийн барагдуулалтад 19000.0 мянга, нийт 242985.4 мянган төгрөгийг зарцуулжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд оруулсан мэдээллийн үнэн зөв, бодитой, иж бүрэн, ойлгомжтой байдал хангалтгүй байна. Тайлант хугацаанд оруулбал зохих 159 мэдээллээс 2 мэдээллийн хугацаа болоогүй, 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 154 мэдээллийг хугацаанд нь оруулсан харагдаж байгаа боловч Шилэн дансны цахим хуудсанд оруулсан ихэнх мэдээллийн иж бүрэн, үнэн зөв, ойлгомжтой байдал нь хангалтгүй байна. Тухайлбал:

Төсвийн хэтрэлт, хэмнэлтийг үнэн зөв гаргаж, түүний шалтгаан тайлбарыг тодорхой, ойлгомжтой бичээгүй, тоо мэдээллийн дэд болон нийт дүнг нэгтгэн тайлагнаагүй, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг сар бүр дутуу тайлагнасан, төсвийн урамшуулал, хандив тусламжийн мэдээ, санхүүгийн болон аудитын тайлан, батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэлийн мэдээлэл, Ковид-19 цар тахалтай хандив, тусламжийн орлого, зарцуулалтын мэдээ мэдээлэл зэргийг дутуу, зөрүүтэй, хэрэглэгчдэд ойлгомжгүй байдлаар тайлагнасан зэрэг алдаа зөрчлүүдийг хойшид давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар бичигдсэн 2367.8 мянган төгрөгийн актыг 100 хувь бүрэн барагдуулж, 78803.5 мянган төгрөгийн 6 алдаа, зөрчлийг таслан зогсоох албан шаардлага, 210851.9 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 12 зөвлөмжийг тус бүр 83 хувьтай биелүүлжээ.

Жич: Өмнөх оны акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг алдаа, зөрчлийн мөнгөн дүн бус тоо хэмжээгээр дүгнэсэн болно.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, төлбөрийн акт, хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	3	2367.8	3	2367.8	0		100%
Албан шаардлага	6	78803.5	5	73044.8	1	5758.7	83%
Зөвлөмж	12	210851.9	10	155344.1	2	55507.8	83%
Нийт дүн	21	292023.2	18	230756.7	3	61266.5	89%

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 750225.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 124217.0 мянган төгрөгийн 6 алдааг залруулж, 3698.4 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 544735.1 мянган төгрөгийн 5 зөрчлийг таслан зогсоох 1 албан шаардлага, 77574.8 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Ковид-19 хандив тусламжаар ирсэн 12862.5 мянган төгрөгийн бараа материалыг данс бүртгэлд тусган тайлагналгүй орхигдуулсан,
2. Нийт 7770.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийн шинж чанар бүхий үндсэн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн,
3. Эм боох материал 6266.0 мянга, сэлбэг хэрэгсэл 3180.0 мянга нийт 9446.0 мянган төгрөгийн бараа материалын зарлага тайланд тусгагдаагүй орхигдсон,
4. Тайлант хугацаан дахь зардлын шинж чанар бүхий хаалга, цонх зэрэг 55100.1 мянган төгрөгийн хөрөнгийг барилгын засварын материалын данс бүртгэлд тусган үлдэгдлээр бүртгэсэн,

5. Үндсэн хөрөнгийн ашиглагдах жилийг программд алдаатай оруулснаар тайлант оны барилга байгууламжийн элэгдлийн зардал 13911.8 мянга, тоног төхөөрөмж 1065.2 мянга, ТЭХ 65.0 мянга, бусад үндсэн хөрөнгө 7760.2 мянга, нийт 22802.2 мянган төгрөгийн элэгдлийн зардалд залруулга хийсэн,
6. Тайлант онд 16236.2 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгслийг хуримтлагдсан элэгдлийн хамт данс бүртгэлээс хасаж тооцоогүй,

Нийт 124217.0 мянган төгрөгийн бүртгэлийн алдаа, зөрчилд залруулга хийв.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 3698.4 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчилд төлбөрийн акт тогтоов. Үүнд:

Пиерли тауэр ХХК-аар гүйцэтгүүлсэн нийт 215492.2 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй агааржуулалтын систем суурилуулах ажлаас 3698.4 мянган төгрөгийн захиалагчийн хяналтын зардал суутган тооцолгүй төлбөрийг шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-д "Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", 41.2.6-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх", 41.2.7-д "Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах", Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан барилгын ажлын захиалагчийн дүрэмд тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

Дараах алдаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

1. Тендерт шалгарсан бэлтгэн нийлүүлэгчдээс бараа, материал худалдан авах гэрээнд тусгай нөхцлийг оновчтой тодохойлоогүйг хэрэгжилтийг үнэлэх шалгуур тодорхой бус,
2. Байгууллагын даргын 2020.10.30-ны А/67 дугаар тушаал шийдвэрийн дагуу эд хөрөнгийн тооллого хийсэн ч, үр дүнгээр хэрэгжүүлсэн ажил хангалтгүй, тасгуудад хандиваар ирсэн зарим эд хөрөнгүүдийг данс бүртгэл, санхүүгийн тайланд тусгаагүй,
3. Тайлант хугацаанд хэрэгжүүлсэн худалдан авах ажиллагааны гэрээний үнийн дүнгээс 504242.5 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг шууд захиалгаар худалдан авсан,
4. Төсвийн төлөвлөлтийг оновчтой төлөвлөөгүйгээс мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланд цалин, нийгмийн даатгалын шимтгэлийг хооронд нь гүйлгэн зарцуулж, бодит зардлаас 40492.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 40 дүгээр зүйлийн 40.3, 40.3.6-д "Худалдан авах гэрээнд энэ хуулийн 40.2-т зааснаас гадна худалдааны нөхцөлийг заавал тусгана", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.2, 72 дугаар зүйлийн 72.4.1, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-д "Хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох", 41 дүгээр зүйлийн 41.2.6-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх", Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2-д "Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", 6 дугаар зүйлийн 6.3.2-д "Санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв бүртгэж, тайлагнах" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Дараах алдаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд оруулсан мэдээллийн үнэн зөв, бодитой, иж бүрэн, хэрэглэгчдэд ойлгомжтой байдал хангалтгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн "4.1.1-д мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, 4.1.2-д мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх, 4.1.3-д тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх, 4.1.4-д хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх" гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 77574.8 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Хөшөөт хөгжил сангийн хөрөнгө оруулалтаар БОЭТ-ийн сургалтын танхим тохижуулах 30000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг Сүүхүнгий ХХК 29283.1 мянган төгрөгөөр гүйцэтгэхээр тендерт шалгарч, 2020 оны 10 дугаар сарын 20-ноос 11 дүгээр сарын 15-ны дотор гүйцэтгэхээр гэрээ байгуулсан боловч тухайн ажил хийгдээгүй, мөн байгууллагын эд хөрөнгийн бүртгэл, тооллого, бүрэн бүтэн байдалд нарийн горим сорил хэрэгжүүлэх нөхцөл бүрдээгүй учир дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Төлбөртэй үйлчилгээний орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Шүдний эмчилгээ, шүдний рентген дэлгэмэл зураг, хамар засах, уламжлалтын шар буурцаг, бүтэн биеийн барианд орсон эмчлүүлэгчдийн бүртгэл, журнал байхгүй, архины эмчилгээ, урьдчилан сэргийлэх үзлэгийн цагаан дэвтрийн бүртгэл журнал дутуу байна.

1.2. Эрсдэл: Орлого дутуу төвлөрөх, орлогын бүрдүүлэлтэд хяналт хэрэгжүүлэх боломж хязгаарлагдах

1.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д "Төсийн шууд захирагч нь ,,,,, тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх үүрэгтэй", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.1.1-д "Ерөнхий нягтлан бодогч нь нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах эрх, үүрэгтэй" гэсэн заалтуудтай нийцүүлж төлбөртэй үйлчилгээнд хамрагдсан үйлчлүүлэгчдийн бүртгэл, журналыг бүрэн хөтлүүлж, санхүүгийн тайлангийн цаглавар хугацаа бүрд кассын няравтай тооцоо нийлж, дотоод хяналтыг хэрэгжүүлж хэвшүүлэх

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

2. Бараа материалын данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Бараа материалын дансны 399121.0 мянган төгрөгийн үлдэгдэлд үндсэн хөрөнгийн шинж чанар бүхий нийт 41 нэр төрлийн 52 ширхэг 55264.1 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэгдсэнээс гадна өмнөх онуудад хийгдсэн вакуум цонх, хаалга, зэрэг зардлын шинж чанартай 22310.7 мянган төгрөгийн хөрөнгийг зарлагдаагүй байна.

2.2 Эрсдэл: Энэ нь санхүүгийн байдал болон үр дүнгийн тайланг үнэн зөв илэрхийлээгүй, бүртгэл тооцооллын холбогдох журам, стандартад нийцэхгүй байх

2.3 Өгсөн зөвлөмж: УСНББОУС-Бараа материалын бүртгэлийн стандарттай нийцүүлж эд хөрөнгийг ангилан бүртгэх

2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Алдаа, зөрчлийн хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧИЙН ЖАГСААЛТ

Огноо:	Аудитын нэр:	Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2020			ХОА-2021/3/СТА-ТШЗСН
Шалгагдсан байгууллагын нэр:	Бүсийн оношилгоо эмчилгээний төв		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	
1	Пиерли тауэр ХХК-аар гүйцэтгүүлсэн нийт 215492.2 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй агааржуулалтын систем суурилуулах ажлаас нийт 3698.4 мянган төгрөгийн захиалагчийн хяналтын зардал суутган тооцож, төлбөрийг шилжүүлээгүй, ажлын гүйцэтгэлд холбогдох хяналтуудыг хэрэгжүүлээгүй байна.	3698.4	Төлбөрийн акт	Дарга, Ерөнхий нягтлан бодогч	Г.Шижир, Д.Баярсүрэн
2	Тендерт шалгарсан бэлтгэн нийлүүлэгчдээс бараа, материал худалдан авах гэрээнд тусгай нөхцлийг оновчтой тодохойлоогүйгээс хэрэгжилтийг үнэлэх шалгуур тодорхой бус	-	Албан шаарлага	Дарга, Ерөнхий нягтлан бодогч	Г.Шижир, Д.Баярсүрэн
3	Байгууллагын даргын 2020.10.30-ны А/67 дугаар тушаал шийдвэрийн дагуу эд хөрөнгийн тооллого хийсэн ч, үр дүнгээр хэрэгжүүлсэн ажил хангалтгүй, тасгуудад хандиваар ирсэн зарим эд хөрөнгүүдийг данс бүртгэл, санхүүгийн тайланд тусгаагүй	-	Албан шаардлага	Дарга, Ерөнхий нягтлан бодогч	Г.Шижир, Д.Баярсүрэн
4	Шүдний эмчилгээ, шүдний рентген дэлгэмэл зураг, хамар засах, уламжлалтын шар буурцаг, бүтэн биеийн барианд орсон эмчлүүлэгчдийн бүртгэл, журнал байхгүй, архины эмчилгээ, урьдчилан сэргийлэх үзлэгийн цагаан дэвтрийн бүртгэл журнал дутуу байна.	-	Зөвлөмж	Дарга, Ерөнхий нягтлан бодогч	Г.Шижир, Д.Баярсүрэн
5	Тайлант хугацаанд хэрэгжүүлсэн худалдан авах ажиллагааны гэрээний үнийн дүнгээс 504242.5 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг шууд захиалгаар худалдан авсан	504242.5	Албан шаардлага	Дарга, Ерөнхий нягтлан бодогч	Г.Шижир, Д.Баярсүрэн
6	Төсвийн төлөвлөлтийг оновчтой төлөвлөөгүйгээс мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланд цалин, нийгмийн даатгалын шимтгэлийг хооронд нь гүйлгэн зарцуулж, бодит зардлаас 40492.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.	40492.6	Албан шаардлага	Дарга, Ерөнхий нягтлан бодогч	Г.Шижир, Д.Баярсүрэн
7	Шилэн дансны цахим хуудсанд оруулсан мэдээллийн үнэн зөв, бодитой, иж бүрэн, хэрэглэгчдэд ойлгомжтой байдал хангалтгүй байна.	-	Албан шаардлага	Дарга, Ерөнхий нягтлан бодогч	Г.Шижир, Д.Баярсүрэн
8	Бараа материалын дансны 399121.0 мянган төгрөгийн үлдэгдэлд үндсэн хөрөнгийн шинж чанар бүхий нийт 41 нэр төрлийн 52 ширхэг 55264.1 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэгдсэнээс гадна өмнөх онуудад хийгдсэн вакуум цонх, хаалга, зэрэг зардлын шинж чанартай 22310.7 мянган төгрөгийн хөрөнгийг зарлагдаагүй байна.	77574.8	Зөвлөмж	Дарга, Ерөнхий нягтлан бодогч	Г.Шижир, Д.Баярсүрэн
9	"Ковид-19 хандив тусламжаар ирсэн 12862.5 мянган төгрөгийн бараа материалыг данс бүртгэлд тусган тайлагнаагүй орхигдуулсан	12862.5	Залруулсан	Дарга, Ерөнхий	Г.Шижир, Д.Баярсүрэн

				нягтлан бодогч	
10	"Нийт 7770.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийн шинж чанар бүхий үндсэн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн,	7770.0	Залруулсан	Дарга, Ерөнхий нягтлан бодогч	Г.Шижир, Д.Баярсүрэн
11	"Эм боох материал 6266.0 мянга, сэлбэг хэрэгсэл 3180.0 мянга нийт 9446.0 мянган төгрөгийн бараа материал залруулж зарлагдсан	9446.0	Залруулсан	Дарга, Ерөнхий нягтлан бодогч	Г.Шижир, Д.Баярсүрэн
12	"Тайлант хугацаан дахь зардлын шинж чанар бүхий хаалга, цонх зэрэг 55100.1 мянган төгрөгийн хөрөнгийг барилгын засварын материалын данс бүртгэлд тусган үлдэгдлээр бүртгэсэн,	55100.1	Залруулсан	Дарга, Ерөнхий нягтлан бодогч	Г.Шижир, Д.Баярсүрэн
13	Үндсэн хөрөнгийн ашиглагдах жилийг программд алдаатай оруулснаар тайлант оны барилга байгууламжийн элэгдлийн зардал 13911.8 мянга, тоног төхөөрөмж 1065.2 мянга, ТЭХ 65.0 мянга, бусад үндсэн хөрөнгө 7760.2 мянга, нийт 22802.2 мянган төгрөгийн элэгдлийн зардалд,	22802.2	Залруулсан	Дарга, Ерөнхий нягтлан бодогч	Г.Шижир, Д.Баярсүрэн
14	" Тайлант онд 16236.2 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгслийг хуримтлагдсан элэгдлийн хамт данс бүртгэлээс хасч тооцоогүй,	16236.2	Залруулсан	Дарга, Ерөнхий нягтлан бодогч	Г.Шижир, Д.Баярсүрэн
ДҮН		750225.3			

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР